



**НИЙСЛЭЛИЙН БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2023 оны 05 сарын 18 өдөр

Дугаар А/97

Улаанбаатар хот

Г Хүүхдийн хөгжлийн хоцрогдол, бэрхшээлээс
урьдчилан сэргийлэх 9, 18, 36 сартай үзлэгийг
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.1 дэх заалт, Засгийн газрын 2021 оны 173 дугаар тогтоолоор батлагдсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын дүрэм”-ийн 1 дүгээр хэсгийн 1.10 дахь хэсэг, Засгийн газрын 2022 оны 33 дугаар хуралдааны тэмдэглэлийн 2.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хүүхдийн хөгжлийн хоцрогдол, бэрхшээлээс урьдчилан сэргийлэх 9, 18, 36 сартай үзлэгийг зохион байгуулахыг Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын дарга (Б.Цогжавхлан)-д үүрэг болгосугай.

2.Урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулахад зарцуулах хөрөнгийн төсвийг хавсралтаар баталсугай.

3.Арга хэмжээнд зарцуулагдах 300,000 (Гурван зуун мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцон ажиллахыг Засаг даргын Эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч (Б.Болормаа)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2023 оны дүгээр сарын ны өдрийн
А/... дугаар захирамжийн хавсралт



9, 18, 36 ХҮҮХДИЙН ЭРТ ИЛРҮҮЛГИЙН ҮЗЛЭГТ ЗАРЦУУЛАГДАХ ТӨСӨВ

№	Материалын нэрс	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ (төг)	Нийт (төг)
1	Анонс (4*3)	м ²	12	10,000	120,000
2	Танилцуулгын самбар (1,8*80)	ш	2	50,000	100,000
3	Халуун хэмжигч	ш	1	80,000	80,000
Нийт дүн					300,000